

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Лочингийн Ишжамц	Дугаар	L022
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Баянгол дүүрэг
Төрсөн газар	Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум	Төрсөн он	1914
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Ганданпунцаглин хийд	Сүм хийдийн дугаар	ХОХХ 076
Одоогийн сүм хийд	Гандантэгчинлэн хийд	Сүм хийдийн дугаар	УВ 01
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 11-р сарын 5	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Ганданпунцаглин хийд буюу Өөлдийн хүрээ

1921 онд 6 настайгаасаа Эрдэнэбүрэн сумын Ганданпунцаглин хийдэд шавилан суусан. 17 жил суусан. 1938 онд сүм хийд тарахад хөдөө гарч 39 жил болсон. Мал маллаж байсан. Ингээд 1976 онд 62 настайдаа Гандан хийдэд хүрж эхэлсэн. 60 гарчихаад ном цээжлэх биш. Хуучин уншиж байсан уншлагаа уншиж байсан. Арван Хангал зэрэг Ганданд хурдаг номнуудыг судар тавилгүйгээр уншдаг.

Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Ганданпунцаглин хийд 500 гаруй ламтай, 5 дацантай байсан. 7 дугантай байсан. Цогчин, Авга, Дашгэмпил, Жүд, Чойр гэсэн 5 дацан байсан. Хийдийн хамба лам нар баригдаад явсан. Аграмба, гавж, гэвш цолтой олон эрдэмтэй сайн лам нар байсан. Би дацангуудын цөмд нь хурдаг байсан. Бүх хурлын ерөөл магтаал, нэр, эм, хамгийн сүүлд зурхай хүртэл үзэж байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ганданпунцаглин хийд хэдэн онд байгуулагдсаныг мэдэхгүй. 100 гаруй жил болсон байсан байх. Хийдийн гол шүтээн нь Ямандаг, Гомбо, Намсрай, Чойжил, Лхам гэсэн 5 шүтээн байсан. За тэгээд хангалууд зөндөө бий. Тоолбол, Шалч, Жамсран, Бэрээвэн, Сэндом, Гонгор.

Гол сахиус нь Ямандаг, Гомбо, Намсрай, Чойжил, Лхам гэсэн шүтээнүүд байдаг. Тогтмол хуралтай байсан. Өдөр бүр цогчин хурна. Чойр, жүд гээд өдөр бүр хурна. Сар тутам эд нарыгаа хурна. Хурал номд Ямандаг, Гомбо, Намсрай, Чойжил, Лхам, Чойр, Жүд гээд хурал хурна.

Цам гарна.Майдар эргэнэ.Майдар зун эргэнэ. Мөн хавар цагаан сараар эргэнэ. Нэг эргэхдээ 2 цаг явна. Дацангийн хүрээг тойрон бүр гадуур нь эргэнэ. Хийдийн хүрээ их том байсан. Цам нь хүрээ дэгтэй цам байсан. Ганжуур, Данжуур эргэнэ. Цагаан сараар саяын хурлуудыг 7 хоног хурна. Богд ламын дүйчэн өдрөөр Богд ламын чог хурна. Хайлан хурдаг байсан. Нүгнээ сахидаг байсан. Чойр дацанд гавж, гэвш, аграмбын дамжаа барина.

Жилд хоёр гурван удаа барьдаг байсан. Гавжийн дамжааг 3 хүн барихдаа нэг нь 9 хоног, аграмбын зиндааг 5 хоног барьдаг байсан.

Чойр дацанд дүйра 5, голын 5, нийтдээ 10 зиндаа байсан.

Цогчин, Дүйнхор, Жүд, Чойр,гэсэн үндсэн 4 жастай байсан. Гадуур жижиг жасууд байсан. Жасын мал хөрөнгөний тухай мэдэхгүй. Лам нар нь цөм хөдөөтэй байсан. Лүйжинч, зодоч нар их ховор байсан. Ганц нэг л хүн байсан.

Би 19 настайдаа 1930 онд гэвш болсон. Хамт сууж байсан хүмүүсээс Лувсан байна. Өөр хүн байхгүй. Хийдийн судар номноос үлдсэн юм байхгүй. Бүгдийг шатаагаад устгачихсан. Миний багш нар бүгд баригдаад явсан. Миний хоёр лам ах, аав хэлмэгдсэн. Олон зуун мянган хүнийг хэлмэгдүүлсэн. Тэр их хөрөнгө,хурал дацангийн юмыг эвдэлж хэмхлээд шороонд булсан. Улсыг хэчнээн хохируулав.Соёлын их үнэт зүйлийг үгүй хийсэн. Чойбалсангийн хийсэн зүйл. Ил юмыг илгээр хааж болохгүй гэж. Энэ Чойбалсагийн хөшөө Монгол улсад хэрэгтэй юм уу, үгүй юм уу. Ирээдүйд энэ зүйлийг хүмүүст мэдүүлэхийн тулд энэ тухайг нь Чойбалсангийн хөшөөнд бичих хэрэгтэй гэж би боддог. Хэрэгтэй юм л хэрэгтэй. Ирээдүйд хэрэггүй юм хэрэггүй.